

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Худалдаа, хөгжлийн банкны хөтөлбөрийн хүрээнд баримтлах бодлогын талаарх мэдэгдэл

1. Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх) нь Монгол улсад бүртгэлтэй ба Монгол улсын Төв Банк (цаашид “Монголбанк” гэх)-ны зохицуулалтад үйл ажиллагаа эрхэлнэ.
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Худалдаа, хөгжлийн банкны бодлого (цаашид “Бодлого” гэх) нь Монгол улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”, Монголбанкны “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” болон бусад холбогдох журам, заавар, дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагуудын зөвлөмж, стандарттай нийцсэн байна.
3. Банк нь Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Аюулгүйн зөвлөл, Америкийн нэгдсэн улсын Сангийн яамны Гадаад Хөрөнгийн Хяналт алба (OFAC), Европын холбоо болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ) болон корреспондент банкнуудын хүсэлтийн дагуу бусад улс, орны Засгийн газрын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. Банкны салбар, тооцооны төв, газар, хэлтэс, түүнд ажиллаж буй ажилтнууд энэ бодлогыг дагаж мөрдөнө.
4. Банкны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТС) хөтөлбөр нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар баримтлах Худалдаа, хөгжлийн банкны бодлого”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Худалдаа, хөгжлийн банкны журам” (цаашид “Журам” гэх) болон Комплайнсын хэлтсээс бэлтгэн гаргасан Гарын авлага, зөвлөмжийн хүрээнд тодорхойлогдох ба хөтөлбөр нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 - (1) Харилцагчийн болон Банкны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ
 - (2) Харилцагчийг баталгаажуулах, таньж мэдэх ажиллагаа
 - (3) Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан ажиллагаа
 - (4) Корреспондент банкны харилцаа
 - (5) Санхүүгийн хориг арга хэмжээ
 - (6) Данс, гүйлгээний тусгайлсан хяналт
 - (7) Тайлан, мэдээ, сэжигтэй гүйлгээ/үйлдлийн талаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх
 - (8) Банкны нийт ажилтнуудад хүргэх сургалт
 - (9) Баримт материал хадгалалт